

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ
ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот 2020 он

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр ямар ч төрд нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалтад нийцүүлэн Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу дараах байдлаар тогтоолоо.

1. Хуулийн этгээд ба иргэний зардал

Иргэн, байгууллагын мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан уг хуулийг хувийн аж ахуй эрхлэх боломжийг хангах болон одоогийн бизнесийнхээ үйл ажиллагааны тэлэлтэд зориулан шаардлагатай нөхцөлд уг мэдээлэлд Засгийн Газраас тогтоож өгсөн үйлчилгээний хөлсийг төлөхөөр тусгалаа. Өнөөдрийн байдлаар уг мэдээлэлтэй холбоотойгоор бизнесүүд судалгааны байгууллагуудаас тухайлсан бүлгээс түүврийн судалгааг ойролцоогоор 5-20 сая төгрөгийн үнэ төлөн хийлгэж байна. Засгийн Газрын батлан мөрдүүлэх үйлчилгээний хөлс нь энэхүү үнэнээс бага байх шаардлагатай ба уг мэдээллийн үнэн бодитой байдал, үнэ цэнэ нь түүврийн судалгаанаас илүү гэж хууль санаачлагчийн зүгээс үзэж байна.

2019 байдлаар бизнес регистерт 187,783 байгууллага бүртгэлтэй байгаагаас 2020 оны 1-р улирлын байдлаар 94,765 нь идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудын 5 хувь (4740) нь уг мэдээллийг улирал тутамд (жилд 4 удаа) авна гэж үзэн тооцоог гаргалаа.

Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт дүн
Мэдээлэл авах зардал	ширхэг	18,960	1,000,000	18,960,000,000

Уг хуулийг хэрэгжүүлснээр иргэн аж ахуйн нэгжээс жилд 18,9 тэрбум төгрөгийг зардал гарах бөгөөд энэ нь улсын төсвийн орлого болно. Энэ иргэн, аж ахуйн нэгжид уг зардлаас хэд дахин өндөр өгөөжийг эргэн өгөх болно.

2. Төрийн байгууллагын хувьд

Хуулийн төслөөр ил тод болгох өгөгдлийг жагсаалт, өгөх журмыг Засгийн Газар тодорхойлох бөгөөд үүнтэй холбоотойгоор уг байгууллагуудад мэдээллийг өгөх орон тооны шинээр ажилтан хэрэггүй бөгөөд шинэ чиг үүргийг тухайлсан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Мэдээллийг өгөхтэй холбоотой техник, эд материалын нэмэлт зардлууд шинээр үүсэхгүй.